

## САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБАНААС ХИЙСЭН ШАЛГАЛТААР

2015 онд 65 байгууллагад хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулахаар 36 албан шаардлага өгч, 46 актаар 102282.5 мянган төгрөгийн төлбөр тогтоогоод байна.

Зөрчлийг ангилан үзвэл: зориулалт бусаар 2332,1 мянган төгрөг, үндсэн баримтгүй зарцуулсан 7612,8 мянган төгрөг, өр авлага үндэслэлгүй хаасан 468,6 мянган төгрөг, илү дутуу олгосон цалин, нөхвөр 87707,4 мянган төгрөг, ашиглаж дутагдуулсан 4164,6 мянган төгрөг.

**Зориулалт бусаар зарцуулсан** зөрчлийг байгууллагаар нь авч үзвэл: Булган сумын ЗДТГ 235,0 мянган төгрөг, Соёл спорт аялал жуулчлалын газар /хуучин нэрээр/ 390,4 мянган төгрөг, Гурванбулаг сумын Цэцэрлэг 50,0 мянган төгрөг, Гурванбулаг сумын Соёлын төв 55,6 мянган төгрөг, Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төв 456,0 мянган төгрөг, Гурванбулаг сумын Бүрэн дунд сургууль 440,0 мянган төгрөг,

**Үндсэн баримтгүй зарцуулсан** зөрчлийг байгууллагаар нь авч үзвэл: Гурванбулаг сумын Бүрэн дунд сургууль 4240,0 мянган төгрөг, Хишиг Өндөр сумын Цэцэрлэг 166,7 мянган төгрөг, Соёл спорт аялал жуулчлалын газар /хуучин нэрээр/ 2166,1 мянган төгрөг

**Ашиглаж дутагдуулсан** зөрчлийг байгууллагаар авч үзвэл: Соёл спорт аялал жуулчлалын газар /хуучин нэрээр/ 92,2 мянган төгрөг, Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төв 2000,0 мянган төгрөг, Гурванбулаг сумын Бүрэн дунд сургууль 1271,3 мянган төгрөг, Хишиг –Өндөр сумын сум дундын эмнэлэг 240,0 мянган төгрөг, НХҮХ 558,1 мянган төгрөг

**Өр авлага үндэслэлгүй хаасан** зөрчлийг байгууллагаар авч үзвэл: Баяннуур сумын ИТХ 278,6 мянган төгрөг, Баяннуур сумын ЗДТГ 190,0 мянган төгрөг

Хяналт шалгалтын дүнг аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХ-ын тэргүүлэгчдэд болон аймгийн вэб сайтад мэдээлэв. Орхон сумын Эрүүл мэндийн төв, сургууль, Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд илэрсэн зөрчлүүдийг шалгуулахаар аймгийн Цагдаагийн газарт шилжүүлсэн.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг “Шилэн дансны нэгдсэн” вэб сайтад 190 байгууллагыг шалгахад 33 байгууллага мэдээллээ байршуулаагүй байна. Тухайлбал: Могод сумын Соёлын төв, ЭМТ, ЗДТГ, ИТХ, Орхон сумын Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, ЭМТ, ЗДТГ, БЗД, ИТХ, Бугат сумын ИТХ, ЗДТГ, БЗД, Бүрэгхангай сумын ИТХ, ЗДТГ, БЗД, ЭМТ, Гурванбулаг сумын ИТХ, ЗДТГ, БЗД, Сэлэнгэ сумын Сургууль, Цэцэрлэг, Соёлын төв, ЗДНС, Тэшиг сумын БЗД, ЗДНС, Сайхан сумын БЗД, ЗДНС, Хялганат тосгоны ойн анги, ЭМТ, Хишиг өндөр сумын сум дундын эмнэлэг, Булган сумын Ойн анги зэрэг 33 байгууллага байршуулаагүй байна.

БЭЛТГЭСЭН:

Д.САРАНГЭРЭЛ